



Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал,
залуучуудын газрын 2024 оны дүгээр сарын ...-ны
өдрийн 37 дугаартай албан бичгийн хавсралт

ХҮНИЙ "НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ"-ИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

№	Холбогдох хүний эрхийн мэдээлэл	Асуудал	Хэрэгжилт
1	Хүний "Нийгэм, соёлын эрх"-ийг хангах чиглэлээр	Хүний нийгэм, соёлын эрх, зохиогчийн эрхийг хангах чиглэлээр хийсэн ажлууд	<p>1. Соёлын яамнаас Зохиогчийн эрхийн тухай хуулийг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 2 удаагийн цахим сургалт зохион байгуулж, соёлын 8 байгууллагын удирдлагуудыг хамрагдаж, мэдээлэл авсан.</p> <p>2. Соёлын байгууллагуудын удирдлага, албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Зохиогчийн эрхийн тухай хууль" сэдвээр сургалт зохион байгуулж, аймгийн СУАЖЗГ-ын 8, харьяа соёлын 7 байгууллагын 115 ажилтанг хамруулж, соёлын салбарт хэрэгжиж буй хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан асуулт, хариулт өрнүүлэн харилцан ярилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>3. Шарын гол сумын Соёлын төв нь аймгийн бэлгэдэл болох Нада бугийн баг өмсгөл хийлгэх асуудлаар Оюуны өмчийн тухай хуульд заасны дагуу зохиогчийн эрх эзэмшигч АЗДТГ-ын Мэдээлэл технологийн албанаас зөвшөөрөл авч, соёлын үйлчилгээг хүүхэд, багачуудад хүргэн ажиллаж байна.</p> <p>4. Музей нь 2024 онд "Дарханы Түүх, Соёл: Эрт, Эдүгээ" эрдэм шинжилгээний хурлын эмхтгэлийн зохиогчийн эрхийн ISBN 978-9919-0-4067, HNA 63, ДАА 900, У-457 тоот кодыг авсан байна.</p> <p>5. Төв номын сангаас "Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх" сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, төрийн болон сангийн үйлчилгээний хүртээмжийг төлөөлөл 24 хүн оролцсон. Хэлэлцүүлэгт оролцогчдоос номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд явуулын номын сан, гэрээр ном олгох үйлчилгээг өргөжүүлэх, аудио ном, шүлэг яруу найраг, 3D ном, танин мэдэхүйн хөтөлбөрүүд хэрэгтэй байгааг онцолсон байна. Үүний дагуу "Харааны бэрхшээлтэй уншигчдад номын сангийн үйлчилгээ үзүүлэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх нь" сэдэвтэй 60.0 сая төгрөгийн төсөл бичиж Дархан сумын ЗДТГ-т хандсан ба улмаар шалгарч тендэр нь зарлагдсан байна.</p> <p>6. Орхон сумын соёлын төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд урлаг, соёлын үзвэр үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг болсон.</p> <p>7. Тус газар нь ХГБХХГ, БТСГ-тай хамтран төрийн 12 байгууллага, хувийн хэвшлийн 10 гаруй дугуйлан, клуб, секц, холбооны 90 гаруй багш, ажилтнуудад Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг</p>

		<p>хамгаалах журмын сурталчлан таниулах зорилгоор сургалт зохион байгуулсан. Тус сургалт нь соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, олон нийтийг хамарсан арга хэмжээ, хүүхэд оролцсон уралдаан, тэмцээний үед хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн.</p> <p>8. Олон Улсын охидын эрхийг хамгаалах өдрийг угтан "Охидын эрх, гэрэлт ирээдүй" өдөрлөгийг ЕБС-ийн ахлах ангийн 120 гаруй сурагчдын дунд зохион байгуулсан. Тус өдөрлөгийн зорилго нь охидод тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, тэдний эрхийг хамгаалах, боловсрол эзэмшүүлж, хөгжүүлэхэд нь анхаарал хандуулах, охидын эрхийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд оршсон.</p> <p>9. Аймгийн ЦГ-ын ЗЦТ-аас зохион байгуулсан сургалтад тус газрын 8 албан хаагчийг хамруулж, замын хөдөлгөөнд оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, дүрмийн талаарх ойлголт, мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, зам тээврийн осол, гэмтлийн хор уршиг, учирч болзошгүй эрсдэл, бусдын эрх, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлж соён гэгээрүүлэх зорилгоор мэдээлэл, зөвлөгөө авсан.</p> <p>10. ХЭҮК-оос зохион байгуулсан "Хүний эрх, эрх чөлөө" сургалтад тус газрын удирдлага, мэргэжилтүүд хамрагдаж, гарын авлага, ном товхимолыг хамт олондоо танилцуулж, мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>11. Аймгийн ХГБХХГ, ЦГ-аас төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан байгууллагын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтад соёлын салбарын 15 албан хаагчид хамрагдан мэдээлэл авч, цаашид тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, авч хэрэгжүүлбэл зохих асуудлын талаар харилцан санал солилцсон.</p> <p>12. Олон Улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан Хүүхдийн номын ордны эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын албан хаагчдын дунд "Бид нэг гэр бүл" өдөрлөг зохион байгуулсан байна.</p> <p>Тус газар болон харьяа соёлын 7 байгууллагад ХЭҮК-оос шаардлага, зөвлөмж өгөөгүй болно.</p> <p>Иргэдээс хүний нийгэм, соёлын эрх, зохиогчийн эрхтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй.</p> <p>-</p> <p>Тус газар болон харьяа соёлын 7 байгууллагад 1-4 үргэлжилж байгаа хүний эрхийн зөрчлийн асуудал байхгүй болно.</p>
2	ХЭҮК-оос шаардлага, зөвлөмж авсан эсэх	
3	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэсэн байдал	
4	Шийдвэрлэгдээгүй хүний эрхийн зөрчлийн талаар	
5	1-4 жил үргэлжилж байгаа хүний эрхийн зөрчлийн асуудал бий эсэх	

НЭГТГЭСЭН:
 ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА..... С.ТУЯА

